



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Шинжлэх Ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь хэсэг, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн дүрмийн 22 дугаар зүйлийн "г", "е" дэх хэсэг, 27 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Гадаадтай хамтарсан төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжүүлж ажиллахыг Тэргүүлэгчдийн газрын дарга (А.Баярбаатар)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэмтэн нарийн бичгийн дарга (Б.Авид)-д тус тус үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Д.РЭГДЭЛ



ГАДААДТАЙ ХАМТАРСАН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи (ШУА)-аас гадаад орнуудын Шинжлэх Ухааны Академи, их сургуулиуд болон олон улсын шинжлэх ухааны байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн хүрээнд хоёр болон олон талт судалгааны төсөл, хөтөлбөр, эрдэмтэн солилцооны ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. "Гадаадтай хамтарсан төсөл" (цаашид "Төсөл" гэх) гэж Монгол Улсын ШУА болон энэхүү журмын 1.1-д заасан байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн хүрээнд хоёр талаас санхүүжүүлэх нөхцөлөөр хэрэгжүүлэх хоёр болон олон талт төслийг хэлнэ.

1.3. "Мобилити төсөл" гэж хоёр тал хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хүрээнд судлаач илгээх, гадаадаас хүлээн авах нөхцөлөөр хоёр талаас санхүүжүүлэх төслийг хэлнэ.

1.4. Гадаадтай хамтарсан төслийн нэг жилийн санхүүжилт 60.0 (жар) сая хүртэл төгрөг, Мобилити төслийн санхүүжилт 20.0 (хорь) сая хүртэл төгрөг байна.

1.5. Мобилити төслийн зардал нь гадаадаас ирэх судлаачдын Монголд томилолтоор ажиллах хугацааны байр, хоолны зардал болон бусад (байгуулсан гэрээг үндэслэнэ), гадаад улсад ажиллах монгол талын судлаач (академийн харьяа хүрээлэн)-ийн замын зардал болон бусад зардал (байгуулсан гэрээг үндэслэнэ)-аас бүрдэнэ. Тухайн төслийн судалгааны бусад зардлыг хэрэгжүүлэгч байгууллага бүрэн хариуцна.

1.6. Төсөл нь Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологи, ШУА-ийн судалгаа хөгжүүлэлтийн тэргүүлэх чиглэл, гадаад бодлогын чиглэлд хамаарсан, ил тод, тэгш өрсөлдөх боломжтой, үр ашигтай байх зэрэг үндсэн зарчимд нийцсэн байна.

Хоёр. Төслийг сонгон шалгаруулах, баталгаажуулах

2.1. Төсөл сонгон шалгаруулах комисс (цаашид "Комисс" гэх)-ыг ШУА-ийн Эрдэмтэн нарийн бичгийн даргаар ахлуулан 7-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр ШУА-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулна.

2.2. Төсөл сонгон шалгаруулах явц, шалгуур үзүүлэлт, хугацаа нь гэрээнээс хамаарч өөр өөр байж болно. Төслийн санал хүлээн авах тухай зарыг тухай бүр ШУА-ийн цахим хуудсаар нээлттэй мэдээлнэ.

2.3. Төсөл сонгон шалгаруулах болон хэрэгжүүлэх үйл ажиллагаа дараах үе шаттай байна.

- 2.3.1. Нээлттэй зарлах;
- 2.3.2. Боловсруулах, мэдүүлэх;
- 2.3.3. Сонгон шалгаруулах;
- 2.3.4. Гэрээ байгуулж баталгаажуулах;
- 2.3.5. Санхүүжүүлэх;
- 2.3.6. Хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд хяналт тавих;
- 2.3.7. Үр дүнг мэдээлэх, тайлагнах, баталгаажуулах;
- 2.3.8. Үр дүнг хүлээлгэн өгөх, санхүүгийн тооцоо хийх;

2.4. Төслийн “Захиалагч” нь Шинжлэх Ухааны Академи болон энэхүү журмын 1.1-д заасан байгууллагууд байна.

2.5. Төслийн гүйцэтгэгч нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд байна.

2.6. Төслийн удирдагч нь (цаашид “Удирдагч” гэх) нь доктор болон түүнээс дээш зэрэгтэй эрдэм шинжилгээний ажилтан байна. Төслийн удирдагчийг гүйцэтгэгчийн хүсэлтээр захиалагчтай зөвшилцөн өөрчилж болно.

2.7. Хүрээлэнгүүд төслийн саналыг эрдмийн зөвлөлийн хурлаараа хэлэлцэн, гаргасан шийдвэрээ доор дурдсан бүрдлийн хамт Тэргүүлэгчдийн газарт ирүүлнэ. Үүнд:

- 2.7.1. Төслийн нэр;
- 2.7.2. Хугацаа (эхлэх, дуусах он, сар);
- 2.7.3. Үндэслэл, хэрэгцээ шаардлага;
- 2.7.4. Үр дүнг хэлээлгэн өгөх хугацаа;
- 2.7.5. Хэрэгжүүлэх ажлын календарчилсан төлөвлөгөө, зардлын задаргаа;
- 2.7.6. Үр дүнгийн даалгавар, шалгуур үзүүлэлт;
- 2.7.7. Үр дүнг нэвтрүүлэх, ашиглах, ашигласнаас олох эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын талаарх төсөөлөл.

2.8. Төслийн удирдагч өмнө хэрэгжүүлсэн ямар нэг төслийн үр дүнг хүлээлгэн өгөөгүй, эсвэл төсөл хэрэгжүүлэх хугацаанд аливаа зөрчил гаргаж байсан бол төслийн сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.

2.9. Төслийн санал тус бүрд дүгнэлт гаргах мэргэжлийн хоёроос доошгүй шинжээч ажиллуулна. Шинжээч нь шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталсан аргачлалын дагуу ажиллана.

2.9.1. Шинжээчийг ШУА-ийн бага чуулганы гишүүдээс ШУА-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар томилно.

2.9.2. Шинжээч 14 хоногт багтаан бичгээр дүгнэлт гаргана.

2.9.3. Санхүүгийн хувьд хянан магадлах шаардлагатай гэж үзсэн саналд санхүүгийн шинжээч томилон ажиллуулж болно.

2.10. Комисс нь шинжээчийн дүгнэлтэд үндэслэн төсөл тус бүрээр үнэлж, 75%-аас дээш оноо авсан төслийн саналыг ШУА-ийн Ерөнхийлөгчид танилцуулна.

2.11. Комиссын эцсийн шийдвэр болон төсөл хамтран хэрэгжүүлэх гадаадын байгууллага хоёр талаас дэмжсэн тохиолдолд төсөл хэрэгжүүлэх тухай эцсийн шийдвэрийг ШУА-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар баталгаажуулна.

2.12. Шалгарсан төслийг ажлын 15 хоногийн дотор багтаан гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

2.13. Төслийн санал болон холбогдох материалын үнэн зөв байдлыг төсөл мэдүүлэгч бүрэн хариуцна.

Гурав. Төслийг хэрэгжүүлэх, гэрээ байгуулах, үр дүн, гүйцэтгэлд хяналт тавих

3.1. Төслийн гэрээг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, хэрэгжүүлэгч хүрээлэнтэй энэ журмын 2.11-д заасан шийдвэр гарснаас хойш 30 хоногт багтаан байгуулна.

3.2. Гэрээг 3 хувь үйлдэнэ. Төслийн төрлөөс хамаарч гэрээний хугацаа өөр өөр байж болно. Гэрээний хугацааг гэрээ байгуулсан өдрөөс эхлэн тооцох бөгөөд төслийг хэрэгжүүлэх хугацаа 3 хүртэл жил байна.

3.3. Тэргүүлэгчдийн газар төслийн хэрэгжилтийн явц, хугацаа, үр дүн, хэрэглээнд нэвтрүүлсэн байдал, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. Төслийн хяналтын зардал тус төслийн нийт зардлын 1 хувиас хэтрэхгүй байна.

3.4. Төслийн удирдагч төслийн явцын тайланг жилд нэг удаа хэрэгжүүлэгч хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлтийг Тэргүүлэгчдийн газарт ирүүлнэ.

3.5. Шаардлагатай тохиолдолд төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт хийхдээ хөндлөнгийн шинжээч ажиллуулж болно. Шинжээч ажиллуулахтай холбогдон гарах зардлыг Тэргүүлэгчдийн газар хариуцна.

3.6. Гэрээнд заасан шаардлагыг хангаагүй үндэслэлээр захиалагч төслийн эцсийн үр дүнг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд уг ажлыг дахин гүйцэтгүүлэх, эсхүл санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

Дөрөв. Төслийн үр дүнг хүлээлгэж өгөх, тайлагнах

4.1. Гүйцэтгэгч төсөл хэрэгжүүлж дууссанаас хойш 60 хоногт багтаан түүний үр дүнгийн тайлан (цахим болон хэвлэмэл хэлбэрээр)-г Монгол Улсын холбогдох стандартын дагуу бичиж, ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт актаар хүлээлгэж өгнө.

4.2. Гүйцэтгэгч үр дүнг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан "Шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үнэлж, хүлээн авсан акт"-ын үлгэрчилсэн загварын дагуу 3 хувь үйлдэж захиалагч, гүйцэтгэгч байгууллага, санхүүжүүлэгч болон төслийн удирдагч тус бүрд нэг хувийг хадгалуулна.

4.3. Хэрэгжилтийн явцад бий болсон оюуны өмчийг өмчлөх, эзэмших асуудлыг Инновацийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

Тав. Бусад

5.1. Төслийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулаагүй, сонгон шалгаруулах, хяналт тавих журам зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Төсөл сонгон шалгаруулж, хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар шийдвэрлэнэ. Гомдол гаргагч энэ шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

--- ооо О ооо ---